



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 27 өдөр

Дугаар А/264

Хэрлэн сум

“Монгол Ардын богино болон уртын
дууны Улсын III уралдаан”-д хөрөнгө
зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, 14.2.3, Соёлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэг, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 15 дугаар хуралдааны 06 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.5.6.3 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор “Монгол Улсын Ардын жүжигчин Чулуунбаатарын Шархүүхэний нэрэмжит Монгол Ардын богино болон уртын дууны Улсын III уралдаан”-д 20,000,000 (хорин сая) төгрөгийн хөрөнгийг зарцуулсугай.

2. Зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Тус зардалд шаардагдах хөрөнгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх “Хэнтийн түүх - бидэнд чухал” арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Нямдаваа)-т, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Д.Өнөрцэцэг)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

Аймгийн Засаг даргын 2023 оны
 04 дугаар сарын 27-ны өдрийн
 А/264 дугаар захирамжийн хавсралт

Нэрт уртын дууч Монгол улсын ардын жүжигчин Чулуунбаатарын Шархүүхэний
 нэрэмжит Уртын дуу, Ардын богино дуу дуулаачдын улсын III – дугаар
 уралдаант наадмын шагнал урамшуулалын зардлын тооцоо

№	Зардлын нэр	Зардлын тоо хэмжээ		Нэгж үнэ	Нийт үнэ
1	Уртын дуу дуулаачдын өргөмжлөл, мөнгөн шагнал	Тэргүүн байр /нэг/		2,500,000	2,500,000
		Дэд байр /нэг/		2,000,000	2,000,000
		Гутгаар байр /нэг/		1,500,000	1,500,000
		Тусгай байр /нэг/		1,000,000	1,000,000
		Нэрэмжит /нэг/		1,000,000	1,000,000
2	Богино дуу дуулаачдын өргөмжлөл, мөнгөн шагнал	Тэргүүн байр /нэг/		2,500,000	2,500,000
		Дэд байр /нэг/		2,000,000	2,000,000
		Гутгаар байр /нэг/		1,500,000	1,500,000
		Тусгай байр /нэг/		1,000,000	1,000,000
		Нэрэмжит /нэг/		1,000,000	1,000,000
3	Шилдэг хөгжмийн хамтлаг	Шилдэг		1,000,000	1,000,000
Уран бүтээлийн шагналын дүн					17,000,000
Шүүгчдийн зардал	Шүүгчдийн хөлс	Хүн/өдөр	500,000	3	1,500,000
	Шүүгчдийн хоол	Хүн/өдөр	15,000	3*3*2	270,000
	Шүүгчдийн буудал	хоног	50,000	3*3	450,000
	Шүүгчдийн унаа/ирэх,буцах	Удаа	30,000	3*2	180,000
Шүүгчдийн дүн					2,400,000
Бусад	Өргөмжлөл 10 ш		4,500		45,000
	Анонс 4x4		12,000		96,000
	Уран бүтээлчдэд ус цай		300,000		300,000
	Бусад зардал		159,000		159,000
Бусад зардлын дүн					600,000
НИЙТ ДҮН					20,000,000